



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Аудитын код: ТӨА-2025/001/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер О.Амаржаргал Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Ц.Саранчимэг Утас: 70273465 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит" ХХК Утас: 99061771 Цахим хаяг: info@imkaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582 Цахим шуудан: tov@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/25
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.БАТЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажилгүйдлийг бууруулах ажлын хүрээнд "Малчдын зөвлөгөөн", "Ажил олгогч-ажил хайгчдын уулзалт", "Хөдөлмөрийн амт" үзэсгэлэн худалдаа, "Нутгаа зорье" арга хэмжээ, Нээлттэй хаалганы өдөрлөг, "Амьдрал хэчнээн сайхан гээч", "Хөдөлмөрийн үр шим", "Амьдралын үнэ цэнэ" лекц зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсны үр дүнд малчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн чадвар, сэтгэлгээ, хандлагад эерэг өөрчлөлтүүд гарсан байна.

Аудитын гол асуудал

Малжуулах арга хэмжээнд хамрагдах шаардлагыг хангасан 180 өрхөд батламж гардуулан нийт 1,439,990.0 мянган төгрөгийн зээлийг олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилт, хэрэгжүүлэх 52 арга хэмжээтэй баталснаас, жилийн эцсийн байдлаар 91,6 хувьтай дүгнэгдсэн

байна. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	2,621,515,008.00	3,044,835,352.00
33	АВЛАГА	2,621,515,008.00	3,044,835,352.00
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	1,789,030,602.00	3,044,835,352.00
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах	881,155,850.00	897,977,000.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	130,641,191.00	124,288,791.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	401,362,061.00	1,572,676,561.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	321,322,500.00	416,499,000.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	29,945,500.00	20,720,500.00
33720	Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл	24,603,500.00	12,673,500.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	832,484,406.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,621,515,008.00	3,044,835,352.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,621,515,008.00	3,044,835,352.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,621,515,008.00	3,044,835,352.00
51200	Хуримтлагдсан үр дүн	2,621,515,008.00	3,044,835,352.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,397,575,053.00	2,621,515,008.00
51220	Тайлант үеийн үр дүн	1,223,939,955.00	423,320,344.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	2,621,515,008.00	3,044,835,352.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,044,855,820.00	3,491,004,801.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	359,731,820.00	3,305,365,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	359,731,820.00	3,305,365,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	359,731,820.00	3,305,365,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,922,487,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	359,731,820.00	382,870,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	7,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,685,124,000.00	185,639,401.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	185,639,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	185,639,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,685,124,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,685,124,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	820,915,865.00	3,067,684,457.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	820,915,865.00	3,067,684,457.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,228,045.00	57,105,420.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,228,045.00	57,105,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,228,045.00	57,105,420.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	784,687,820.00	3,010,579,037.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	284,165,600.00	261,926,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	284,165,600.00	261,926,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	500,522,220.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	500,522,220.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,748,652,936.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,748,652,936.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,223,939,955.00</u>	<u>423,320,344.00</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,223,939,955.00</u>	<u>423,320,344.00</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,044,855,820.00</u>	<u>4,323,489,206.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,044,855,820.00	4,137,849,806.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,044,855,820.00	4,137,849,806.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,044,855,820.00	4,137,849,806.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,685,124,000.00	2,922,487,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	359,731,820.00	382,870,900.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	832,484,406.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	7,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	185,639,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	185,639,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	185,639,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,226,378,051.00</u>	<u>5,297,674,456.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,226,378,051.00	5,297,674,456.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,106,045.00	57,105,420.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,106,045.00	57,105,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,106,045.00	57,105,420.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,185,272,006.00	5,240,569,036.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,352,787,600.00	2,491,916,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,352,787,600.00	2,491,916,100.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	832,484,406.00	2,748,652,936.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	832,484,406.00	2,748,652,936.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	- 181,522,231.00	- 974,185,250.00
14	Бусад эх үүсвэр	-	974,185,250.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	974,185,250.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	974,185,250.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	- 181,522,231.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	974,185,250.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	- 682,044,451.00	-

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,621,515,008.00	0.00	2,621,515,008.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,621,515,008.00	0.00	2,621,515,008.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,621,515,008.00	0.00	2,621,515,008.00
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,621,515,008.00	0.00	2,621,515,008.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,621,515,008.00	0.00	2,621,515,008.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	423,320,344.00	0.00	423,320,344.00
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,044,835,352.00	0.00	3,044,835,352.00

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал		ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
Код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	1,393,893,645.00	2,549,021,520.00
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	6,621,550.00	6,356,250.00
12	Татварын бус орлого	6,700,000.00	6,700,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,700,000.00	6,700,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	6,700,000.00	6,700,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,621,550.00	6,356,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,621,550.00	6,356,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,621,550.00	6,356,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	6,621,550.00	6,356,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,621,550.00	6,356,250.00
82602	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	161,081,500.00	144,630,000.00
12	Татварын бус орлого	249,068,020.00	155,350,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	249,068,020.00	155,350,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	161,081,500.00	144,630,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	161,081,500.00	144,630,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	137,994,000.00	382,870,900.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	137,994,000.00	382,870,900.00
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	137,994,000.00	382,870,900.00
82619	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	21,756,000.00	11,609,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,756,000.00	11,609,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,756,000.00	11,609,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,756,000.00	11,609,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,756,000.00	11,609,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,756,000.00	11,609,100.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,428,000.00	23,286,500.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	31,428,000.00	23,286,500.00
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	31,428,000.00	23,286,500.00
300011	Орлого төвлөрүүлэн шилжүүлэх	-	10,000,000.00
82620	Хөдөлмөрт бэлтгэх сургалт	31,270,000.00	22,660,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,270,000.00	22,660,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,270,000.00	22,660,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,270,000.00	22,660,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,270,000.00	22,660,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,270,000.00	22,660,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,550,000.00	57,550,000.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	57,550,000.00	57,550,000.00
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	57,550,000.00	57,550,000.00
82621	Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	1,023,165,200.00	2,183,490,000.00
12	Татварын бус орлого	663,470,600.00	2,278,404,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	663,470,600.00	2,278,404,800.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	663,470,600.00	2,278,404,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,023,165,200.00	2,183,490,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,023,165,200.00	2,183,490,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,023,165,200.00	2,183,490,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,023,165,200.00	2,183,490,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,023,165,200.00	2,183,490,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,012,687,851.00	1,391,320,800.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	330,643,400.00	1,391,320,800.00
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	330,643,400.00	1,391,320,800.00

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан			
32	ЗГ-ын гадаадын төслийн зээл	682,044,451.00	974,185,250.00
321102	Үндсэн төлбөр (ЗГ-ын дотоод зээл)	682,044,451.00	974,185,250.00
82622	Түр ажлын байрыг дэмжих	123,260,000.00	129,527,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	123,260,000.00	129,527,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	123,260,000.00	129,527,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,260,000.00	129,527,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	123,260,000.00	129,527,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	123,260,000.00	129,527,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	217,880,000.00	300,980,000.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	217,880,000.00	300,980,000.00
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	217,880,000.00	300,980,000.00
82623	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал	26,739,395.00	50,749,170.00
12	Татварын бус орлого	-	63,256,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	63,256,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	-	63,256,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,739,395.00	50,749,170.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,739,395.00	50,749,170.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,739,395.00	50,749,170.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	26,739,395.00	50,749,170.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,739,395.00	50,749,170.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	53,000,000.00	185,639,400.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	53,000,000.00	185,639,400.00
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	53,000,000.00	185,639,400.00
300011	Орлого төвлөрүүлэн шилжүүлэх		185,639,400.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

3.1 Аудитаар нийт 8,148,131.2 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 8,148,131.2 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөрийн цахим баримтын цахим системийн нэхэмжлэх дээр 17 байгууллагын 8,148,131.2 мянган төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй	1	8,148,131.2					1	8,148,131.2				
Нийт 6 хөтөлбөрийн 57,237.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлээгүй	1	57,237.8					1	57,237.8				
Дүн	2	8,205,369.0	0	-	0	-	2	8,205,369.0				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 17,203.5 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс, 17,203.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийт 6 хөтөлбөрийн 4 иргэнтэй холбоотой 17,203.5 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй	1	17,203.5					1	17,203.5				
Дүн	1	17,203.5					1	17,203.5	0	-	0	-

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 147, хугацаа хоцорч мэдээлсэн 7, хүлээгдэж байгаа 5 мэдээлэл байна. Шилэн дансанд мэдээлсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг Мөнгөн гүйлгээний журналын орлого, зарлагын дүнтэй тулгахад тохирч байна.	1	-			1	-
Дүн	1	-			1	-